



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 02 сарын 03 өдөр

Дугаар А/85

Хэрлэн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, төсвийн тухай хуулийн 58.2.17, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.1, 26.1.4, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1-д заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. 2017 онд тус аймгийн Өмнөдэлгэр, Жаргалтхаан, Баян-Адрага, Биндэр, Мөрөн, Хэрлэн сумдын нутагт гарсан мал, амьтны гоц халдварт "Хонины цэцэг" өвчнийг цомхотгон дарах үйл ажиллагааны зардлыг тооцож олгосугай.

Хоёр. Зардлын төрөл, мөнгөн дүнг хавсралтаар баталсугай.

Гурав. "Хонины цэцэг" өвчинтэй тэмцэх үйл ажиллагааны зардал 650000 /Зургаан сая таван зуун мянга/ төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгийн гамшигтай тэмцэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д зөвшөөрсүгэй.


Дөрөв. Энэхүү захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, ажиллахыг Засаг даргын орлогч Г.Хэрлэнчулуунд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБАЯМБА

Аймгийн Засаг даргын 2017 оны 02
дугаар сарын 03 ны өдрийн 13 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт



ЗАРДЛЫН НЭР ТӨРӨЛ, МӨНГӨН ДҮН

№	Сумдын нэрс	Хоол, хүнс	Шатахуун	Дүн
1	Биндэр	100000	400000	500000
2	Жаргалтхаан	-	800000	800000
3	Өмнөдэлгэр	-	2300000	2300000
4	Мөрөн	100000	400000	500000
5	Хэрлэн	-	1000000	1000000
6	Өлзийт	-	500000	500000
7	Ажлын хэсэг		900000	900000
	Дүн			6500000